

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ  
(2021.01.02-2021.12.24)**

2021 оны 12 дугаар сарын 24

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 187 албан бичиг ирснээс, хариутай бичиг 95, хариугүй бичиг 92 байгаагаас Удирдлагад 9, Захиргааны албанд 145, Үйлдвэрлэл, технологийн албанд 33 албан бичиг хуваарилагдан тус тус шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) тогтмол, бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 98.95% (1 албан бичгийн шийдвэрлэлт коронавирусын вакцин хийх багийн ажлын хуваариас шалтгаалан хоцорсон.), хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 99,16%-тай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.14 хоног.


Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлд үндэслэн, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга, Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Тоон гарын үсгээр илгээгдэж буй баримт бичгүүдийг хэвлэн авч, ХУУЛБАР ҮНЭН тэмдгээр баталгаажуулан ашиглаж байна.

Манай байгууллагаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагууд руу нийт 201 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийг 2021 оны 01-04 дүгээр улирлын байдлаар, мөн өнгөрсөн оны мөн үеийн байдлаар харьцуулан харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

(2021 оны 01 - 04 дүгээр улирлын албан бичгийн шийдвэрлэлтийг харьцуулахад, графикаар)




**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

(2021 оны 01 – 04 дүгээр улирлынхыг харьцуулахад,  
тоон үзүүлэлтээр)

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2021 оны 1-р улирал	53	23	30	2.18	39
2021 оны 2-р улирал	51	27	24	3.76	52
2021 оны 3-р улирал	47	25	22	3.57	33
2021 оны 04 дүгээр улирал	51	29	22	2.96	72
<b>2021 онд Нийт</b>	<b>185</b>	<b>95</b>	<b>90</b>	<b>3.17</b>	<b>202</b>

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

(2021 оны албан бичгийн шийдвэрлэлтийг 2020 оныхтой харьцуулахад, графикаар)




**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

(2021 оныхыг 2020 оныхтой харьцуулахад,  
тоон үзүүлэлтээр)

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2020 он	207	84	113	3.02	244
2021 он	185	95	92	3.14	201

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 3.02 байсан бол энэ онд 3.14 хоног байна.

ХЯНАСАН:  
 “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *С.ЭЛБЭГСАЙХАН*



ТАЙЛАНТ АРГАСАН:  
 БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД ХАРИЛЦАА  
 ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *М. МӨНХДУЛАМ*